



“НЬЮ КАПИТАЛ ТЭНЦЭЛ АУДИТ” ХХК
АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЗӨВЛӨГӨӨ, ХЯНАЛТЫН НЭГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

“АДУУН ЧУЛУУН” ХК

**2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр
дуусвар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАН
Аудиторын дүгнэлтийн хамт**

2024

АГУУЛГА

Байгууллагын талаарх мэдээлэл	3
Удирдлагын хариуцлагын талаарх мэдэгдэл	4
Хараат бус Аудиторын Дүгнэлт	6-7
Санхүүгийн байдлын тайлан	8-9
Орлогын дэлгэрэнгүй тайлан	10
Өмчийн өөрчлөлтийн тайлан	11
Мөнгөн гүйлгээний тайлан	12-13
Санхүүгийн тайлангийн тэмдэглэл	14-20

Байгууллагын талаарх мэдээлэл
Үүсгэн байгуулах шийдвэр

“АДУУН ЧУЛУУН” ХК нь 1955 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол улсын Засгийн газраас 1995 онд орон нутгийн өмчид шилжүүлж, төрийн өмчийн хорооноос тус уурхайг 90 хувь төрийн өмч давамгайлсан хувьцаат компани болгон өөрчилсөн. Тус компани нь нүүрс олборлох, тээвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Монгол улсын Засгийн газрын хувьчлагдах үйлдвэр, аж ахуйн жагсаалтын дагуу 1999 оны 8 дугаар сард дуудлага худалдаагаар хувийн өмчит компани болсон.

Гэрчилгээ ба Лиценз

Улсын бүртгэлийн дугаар:
Регистрийн дугаар: 2011239

Тусгай зөвшөөрөл:

Уул уурхай эрхлэх тусгай зөвшөөрөлтэй

Хөрөнгөө оруулагчид

Нийт 891,231.8 мянган төгрөгийн дүрмийн сантай байна.

Төлөөлөн Удирдах
Зөвлөл

<i>Б.Шатар</i>	<i>ТУЗ-ийн дарга</i>
<i>Ш.Мягмарсүрэн</i>	<i>ТУЗ-ийн гишүүн</i>
<i>Ш.Бямбасүрэн</i>	<i>ТУЗ-ийн гишүүн</i>
<i>Ш.Идэр</i>	<i>ТУЗ-ийн гишүүн</i>
<i>Ш.Баясгалан</i>	<i>ТУЗ-ийн гишүүн</i>
<i>М.Шинэтогтох</i>	<i>ТУЗ-ийн гишүүн</i>

<i>С.Бадарч</i>	<i>ТУЗ-ийн хараат бус гишүүн</i>
<i>Д.Амаржаргал</i>	<i>ТУЗ-ийн хараат бус гишүүн</i>
<i>Б.Батсайхан</i>	<i>ТУЗ-ийн хараат бус гишүүн</i>

Гүйцэтгэх Удирдлага

Ш.Баясгалан *Гүйцэтгэх захирал*

Хаяг

“АДУУН ЧУЛУУН” ХК
Хаяг: Дорнод аймаг, Хэрлэн сум, 8 дугаар баг, Адуун чулуун ХК-ний байр
Tel: (+976)-89105818, (+976)- 99102892

Аудитор

“НЬЮКАПИТАЛ ТЭНЦЭЛ АУДИТ” ХХК

Хаяг: Дорнод аймаг, Хэрлэн сум, 9-р баг “Сити центр”, 5 дугаар давхарт
Tel: (+976) – 70582688, (+976)–99992596
Mail: ts.bayarbold@gmail.com

**2023 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусвар болсон жилийн
санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх
Удирдлагын хариуцлагын мэдэгдэл**

Энэхүү тайлангийн хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь “АДУУН ЧУЛУУН” ХК-ийн (“Компани” гэх) 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

“АДУУН ЧУЛУУН” ХК-ийн удирдлага бид эдгээр санхүүгийн тайлангуудыг СТОУС болон түүнд нийцүүлэн, гаргасан нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой хууль, заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд санхүүгийн тайлангууд нь 2023 оны 12 дугаар сарын 31 -наарх санхүүгийн байдал, тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг Сангийн яамнаас гаргасан санхүүгийн тайлагналын холбогдолтой журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн.

Санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлага нь дараах зүйлсэд хариуцлага хүлээдэг. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тохирох зарчмуудыг сонгож, тууштай хэрэгжүүлэх;
- Ул үндэстэй бөгөөд оновчтой шийдэл болон тооцоолол хийх;
- СТОУС болон Сангийн яамнаас гаргасан журам зааврыг даган мөрдсөн эсэх болон мөрдөөгүй зүйлсийн талаар нэмэлт тодруулга, тайлбар хийсэн эсэх талаар дурдах;
- Компани ойрын ирээдүйд бизнесээ үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг өөдрөг ажиллагааны төсөөлөлд үндэслэж бэлтгэх үүргийг хүлээдэг.

Удирдлага нь дараах үүргийг хүлээнэ.

- Дотоод хяналтын үр дүнтэй, тууштай систем боловсруулж, хэрэгжүүлж, ажиллуулах
- Сангийн яамнаас гаргасан нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн заавар журам, холбогдох Монгол улсын хуулийг дагаж мөрдөж нягтлан бодох бүртгэлийг хөтлөх ажиллагааг зохион байгуулах
- Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Заль мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.

Бид эдгээр үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

“АДУУН ЧУЛУУН” ХК-ийн удирдлагын хувьд 2023 оны 12 сарын 31 -ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайлангуудыг гаргахыг 2024 оны 01 сарын 15-ний өдөр батлав.

Ш.Баясгалан
Гүйцэтгэх Захирал

Б.ТЭНГИС
Ерөнхий нягтлан бодогч

Огноо: 2024.01.15

Чойбалсан хот



“НЬЮ КАПИТАЛ ТЭНЦЭЛ АУДИТ” ХХК
АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЗӨВЛӨГӨӨ, ХЯНАЛТЫН НЭГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

Дорнод аймаг, Хэрлэн сум, 9-р баг, Сити центр төвийн
5 дугаар давхарт
Tel: (+976) – 70582688, (+976)–99992596
Mail: ts.bayarbold@gmail.com

Г “АДУУН ЧУЛУУН” ХК -ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

.....2024.02.12..... №

танай-ны № -Т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “АДУУН ЧУЛУУН” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөрх жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийн хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн бүртгэл хөтлөлтийн дэлгэрэнгүйгээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “АДУУН ЧУЛУУН” ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлангийн Олон Улсын Стандарт болон Монгол улсын мөрдөж байгаа холбогдох заавар, журмын дагуу үнэн зөв, толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын стандартын (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлага энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага хэсэгт харуулсан. Бид Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус бөгөөд хуулиар шаардсан шаардлагын дагуу ёс зүйн үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадна гэж үзлээ.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн зохих бодлогыг сонгож, хэрэглэх тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг үнэн зөв хийж санхүүгийн тайланг үнэн зөв тооцож гаргах нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлыг тодруулах ба нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах үүрэгтэй. Бид аудитаа Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбооноос гаргасан Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын ажил нь санхүүгийн тайлан дах дүн болон тодруулгын үндэслэлийг тестийн үндсэн дээр нягтлах, үнэн зөвийг батлах ажлыг багтаадаг.

Санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдлийн үнэлгээг хийхэд байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш бөгөөд тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв бэлтгэхтэй холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг. Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцоонууд, хэрэглэсэн зарчмудыг шалгах ажлыг өөртөө агуулдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол улсын “Компанийн тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох “АДУУН ЧУЛУУН” ХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан тайлангууд болон тодруулга хүртэлх 1-... хуудсан дах тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

ЗАХИРАЛ



Ц.БАЯРБОЛД

“АДУУН ЧУЛУУН” ХК

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

(мянган төгрөг)


	Тодот гол	2022-12-31	2023-12-31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3	779,572.5	4,033.1
Дансны авлага	4	954,388.3	1,022,125.3
Татвар, НДШ-ийн авлага		2,974.5	6,531.1
Бусад авлага			
Бусад санхүүгийн хөрөнгө			
Бараа материал	5	1,489,485.6	1,395,319.3
Эргэлтийн бусад хөрөнгө	6	92,554.4	77,925.1
Эргэлтийн хөрөнгийн дүн		<u>3,318,975.4</u>	<u>3,505,934.0</u>
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	7	3,728,198.5	3,196,514.6
Биет бус хөрөнгө			7,653.2
Хайгуул үнэлгээний хөрөнгө			194,900.7
Бусад эргэлтийн бус хөрөнгө		44,000.0	44,000.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		<u>3,772,198.5</u>	<u>3,443,068.5</u>
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		<u>7,091,173.8</u>	<u>5,949,002.5</u>
ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ			
Богино хугацаат өглөгийн дүн	8	768,411.5	1,037,001.4
Урт хугацаат өглөгийн дүн			
Өр төлбөрийн дүн		<u>768,411.5</u>	<u>1,037,001.4</u>
Эздийн өмч:			
Төрийн өмч			
Хувийн өмч	9	970,613.1	970,613.1
Нэмж төлөгдсөн капитал		-425,199.8	-425,199.8
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		4,883,798.1	4,883,798.1
Халаасны хувьцаа		-174,466.3	-174,466.3
Хуримтлагдсан ашиг		1,068,017.2	-342,744.0
Эздийн өмчийн дүн		<u>6,322,762.3</u>	<u>4,912,001.1</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧИЙН ДҮН		<u>7,091,173.8</u>	<u>5,949,002.5</u>

NEW CAPITAL
TENTSEL AUDIT Co., Ltd

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

“АДУУН ЧУЛУУН” ХК
2023 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон жилийн
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

	Тэмдэглэл	(мянган төгрөг)	
		2022.12.31	2023.12.31
Борлуулалтын орлого (цэвэр)		6,133,396.1	5,388,651.7
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		5,083,860.6	5,951,794.3
Нийт ашиг		1,049,535.5	-563,142.6
Түрээсийн орлого			
Хүүний орлого	10	23,009.9	328.5
Нөгдол ашгийн орлого			
Эрхийн шимтгэлийн орлого			
Санхүүгийн ба бусад орлого			
Бусад орлого		112,075.9	88,196.5
Борлуулалт маркетингийн зардал		138,189.9	141,540.8
Ерөнхий удирдлагын зардал	11	686,054.1	
Санхүүгийн зардал			
Бусад зардал		536,732.6	663,700.8
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)		-310.9	-1,659.3
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)			
Бусад ашиг (алдагдал)			
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		-176,666.2	-1,281,518.5
Орлогын татварын зардал	12		
Тайлант үеийн орлогын татварын зардал			
Татварын дараах ашиг (алдагдал)		-176,666.2	-1,281,518.5
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)			
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)		-176,666.2	-1,281,518.5
Бусад дэлгэрэнгүй орлого			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү			
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			
Бусад олз (гарз)			
Орлогын нийт дүн			
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)			



Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

“АДУУН ЧУЛУУН” ХК

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	(мянган төгрөг)			
Үзүүлэлт	Өмч	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт
2022 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	970,613.1	4,583,515.9	1,068,017.2	6,322,762.3
НБББ-ын өөрчлөлтийн нөлөөлөл, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл	970,613.1	4,583,515.9	1,068,017.2	6,322,762.3
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-1,281,518.5	-1,281,518.5
Бусад дэлгэрэнгүй орлого Өмчид гарсан өөрчлөлт Зарласан ногдол ашиг			-129,242.8	-129,242.8
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	970,613.1	4,583,515.9	-342,744.0	4,912,001.1

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.



“АДУУН ЧУЛУУН” ХК
2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2022.12.31 (мянган төгрөг)	2023.12.31 (мянган төгрөг)
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)		5,371,216.7
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		5,358,797.9
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		11,027.9
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого		1,590.9
Мөнгөн зарлагын дүн (-)		6,019,079.7
Ажилчдад төлсөн		1,673,418.0
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		512,029.5
Бараа материал худалдан авахад төлсөн		3,092,212.3
Ашиглалтын зардалд төлсөн		
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		2,414.5
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн		384,295.8
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага		354,709.7
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-647,863.0
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)		328.5
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого		328.5
Хүлээн авсан ногдол ашиг		
Мөнгөн зарлагын дүн (-)		1,056.5
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		1,056.5
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн мөнгө		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
Бусад		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-728.0
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)		670,007.7

NEW CAPITAL
TENTSEL AUDIT 670,007.7

Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		670,000.0
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргасанаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		7.7
Ханшны зөрүүний олз		
Мөнгөн зарлагын дүн (-)		796,956.0
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		786,533.5
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		8,700.0
Хувьцаа буцаан авахад төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
Ханшны зөрүүний гарз		1,722.5
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-126,948.3
Валютын ханшийн зөрүү		
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ		-775,572.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		779,572.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	779,572.5	4,033.1

NEW CAPITAL 4,033.1
 TENTSEL AUDIT Co., Ltd

Эдгээр санхүүгийн тайланг холбогдох тодруулгын хамтаар уншина уу.

1. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

“АДУУН ЧУЛУУН” ХК нь 1955 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол улсын Засгийн газраас 1995 онд орон нутгийн өмчид шилжүүлж, төрийн өмчийн хорооноос тус уурхайг 90 хувь төрийн өмч давамгайлсан хувьцаат компани болгон өөрчилсөн. Тус компани нь нүүрс олборлох, тээвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Монгол улсын Засгийн газрын хувьчлагдах үйлдвэр, аж ахуйн жагсаалтын дагуу 1999 оны 8 дугаар сард дуудлага худалдаагаар хувийн өмчит компани болсон.

Хувьцаа эзэмшигчдийн 891,239.8 мянган төгрөгийн дүрмийн сантай байна. Улсын бүртгэлийн гэрчилгээнд 2018 оны 03-р сарын 30-ны өдөр Шатар овогтой Баясгаланг гүйцэтгэх захирлаар томилсныг бүртгэсэн байна.

Улсын бүртгэлийн дугаар	
Регистрийн дугаар	2011239
“Нүүрс олборлох” эрхлэх гэрчилгээ авсан огноо	1999/08/01
Хаяг: Дорнод аймаг, Хэрлэн сум, 8 дугаар баг, Адуун чулуун ХК-ний байр	

2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГЫН ХУРААНГУЙ

2.1 Мөрдсөн стандарт

2023 оны 12-р сарын 31-нээрх Компанийн санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын (СТОУС) дагуу бэлтгэж, тайлагнасан болно.

2.2 Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Санхүүгийн тайланг зарим үндсэн хөрөнгөөс бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт үндэслэн бэлтгэсэн. Нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгаснаар зарим үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн үнэ буюу бодит үнэ цэнээр бүртгэсэн. Түүхэн өртөг нь хөрөнгийг худалдан авах үед төлсөн эсвэл солилцсон зүйлийн бодит үнэ цэнэ байдаг.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг компаний үйл ажиллагааны үндсэн мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр илэрхийлсэн. Санхүүгийн тайлангуудыг өөрөөр заагаагүй бол мянган төгрөгөөр илэрхийлсэн.

2.3 Нягтлан бодох бүртгэлийн тооцоолол

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал тооцоолол, үнэлэмж хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнагдсан хөрөнгө, өр төлбөрийн дүн, болзошгүй хөрөнгө, өр төлбөрийн тодруулга болон тайлант үед хүлээн зөвшөөрөгдсөн орлого, зардлын дүнд тус тус нөлөөлдөг. Ирээдүйд гарах бодит үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол, түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг байнга хянадаг. НББ-ын тооцоололд хийсэн өөрчлөлтийг өөрчлөлт хийгдсэн тайлант үе болон ирээдүйн тайлант үеүдэд тус тус тусгадаг.

Дараах санхүүгийн тайлангийн их хэмжээний дүн бүхий үзүүлэлтүүдийг таамаглал төсөөллийг ашиглан, санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн.

“АДУУН ЧУЛУУН” ХК

2023 он 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

2.3.1. Дансны ба бусад авлагын эргэн төлөгдөх байдал

Компани тайлант хугацааны эцэст дансны ба бусад авлагын эргэн төлөгдөх байдлыг хянадаг. Компани дансны ба бусад авлагын эргэн төлөгдөх магадлалыг тухайн авлагын насжилт, уг харилцагчийн зээлийн түүх болон санхүүгийн гүйцэтгэлд үндэслэн тооцоолдог.

2.4 Санхүүгийн хэрэгсэл

Компани тухайн хэрэгслийн гэрээний нэг оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө эсвэл санхүүгийн өрийг санхүүгийн байдлын тайланд тусгадаг.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх үүсэх үеийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Санхүүгийн хэрэгсэл (бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслээс бусад)-ийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг анх бүртгэлд тусгахдаа санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дээр нэмж эсвэл ба өр төлбөрийн бодит үнэ цэнээс хасч бүртгэнэ. Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг шууд тухайн жилийн ашиг алдагдлаар бүртгэнэ.

2.5 Санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгийн хэрэгслийг дараах байдлаар ангилдаг. Үүнд: бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хэрэгсэл, гэрээний хугацаа дуустал эзэмших хэрэгсэл, арилжаалах боломжтой хэрэгсэл ба зээл ба авлага болно. Энэхүү ангилал нь тухайн санхүүгийн хөрөнгийн мөн чанар болон тэдгээрийг ямар зориулалтаар эзэмшиж байгаагаас хамаарах ба анх бүртгэхдээ ангиллыг тогтоодог. Ердийн журмаар худалдах, худалдан авах санхүүгийн хөрөнгийг бодит гүйлгээ гарсан өдрөөр нягтлан бодох бүртгэлд тусгах эсвэл бүртгэлээс хасдаг. Ердийн журмаар худалдах, худалдан авах гэдэг нь тогтоосон хугацааны дотор эсвэл тухайн зах зээл дээр тогтсон дүрэм журмаар хөрөнгийг шилжүүлэх нөхцлөөр санхүүгийн хөрөнгийг худалдах, худалдан авахыг хэлнэ.

Компанийн санхүүгийн хөрөнгө нь зээл ба авлагаас бүрдэж байна.

2.5.1 Зээл ба авлага

Зээл ба авлага нь идэвхитэй зах зээл дээр арилжаалагддаггүй бөгөөд тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөрийн хуваарьтай үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг хэлнэ. Зээл ба авлага (үүнд дансны ба бусад авлагууд, касс болон харилцах, хадгаламжин дахь мөнгөн хөрөнгө багтана)-ыг бодит хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөс үнэ цэнийн бууралтыг нь хассан дүнгээр хэмжиж илэрхийлдэг. Хүүгийн орлогыг бодит хүүгийн аргаар тооцож бүртгэдэг боловч хүүгийн орлого нь материаллаг бус богино хугацааны авлагад нэрлэсэн хүүгийн хувиар орлогыг бүртгэдэг.

2.5.2 Санхүүгийн хөрөнгийг бүртгэлээс хасах

Компани нь санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн гүйлгээг авах гэрээний эрхийн хугацаа дууссан, эсвэл санхүүгийн хөрөнгө шилжүүлсэн, хөрөнгийг эзэмшихтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг бусад шилжүүлсэн бол санхүүгийн хөрөнгийг данснаас хасна. Хэрвээ Компани нь санхүүгийн хөрөнгийг шилжүүлээгүй боловч санхүүгийн хөрөнгийг эзэмшихтэй холбоотой ихэнх эрсдэл ба өгөөжийг хадгалж үлдээгүй бол уг хөрөнгөөс Компанид үлдсэн хувь хэмжээгээр хөрөнгийг бүртгэлдээ хэвээрээ үлдээх ба төлбөр төлөх үүрэг байгаа бол холбогдох өрийг бүртгэнэ.

2.6 Бараа материал

Бараа материалыг өртөг ба цэвэр борлогдох үнийн аль багаар тайлагнадаг. Бараа материалын өртөгт бараа материалыг худалдан авах, үйлдвэрлэх өртөг буюу хувиргалтын зардлууд болон

барааг одоогийн шинж байдал болон байрлалд авчрах хүртэл гарсан бүх зардлаас бүрддэг ба сарын жигнэсэн дунджийн аргыг ашиглан өртгийг тодорхойлдог.

Үйлдвэрлэсэн бараа материал болон дуусаагүй үйлдвэрлэлийн өртөгт хэвийн үйл ажиллагааны хүчин чадлаар тооцсон үйлдвэрлэлийн нэмэлт зардлын зохих хэсгийг оруулдаг.

Цэвэр борлогдох үнэ гэдэг нь хэвийн бизнесийн үед бараа материалын худалдан борлуулах үнээс түүнийг үйлдвэрлэх болон борлуулахад гарахаар тооцоолсон зардлыг хассан дүн юм.

2.7 Үндсэн хөрөнгө

2.7.1 Бусад үндсэн хөрөнгө

Үйлдвэрлэлийн болон бараа үйлчилгээ хүргэх зориулалтаар болон захиргаа аж ахуйн зориулалтаар эзэмшиж буй барилгуудыг үнэлгээ хийх үеийн бодит үнэ цэнэ болох дахин үнэлгээний үнээс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр санхүүгийн байдлын тайланд тусгасан. Тайлант хугацааны эцэст барилгын дансны үнэ нь бодит үнэ цэнээс их хэмжээгээр өөрчлөгдсөн, зөрсөн эсэхийг магадлахын тулд дахин үнэлгээг аль болох ойр ойрхон гүйцэтгэдэг.

Байшин барилгын дахин үнэлгээнээс үүссэн тухайн жилийн үнийн өсөлтийг иж бүрэн орлогын хэсэгт тусгадаг ба өмчийн хэсэгт хуримтлуулан бүртгэдэг. Харин өмнөх жилийн үнэлгээгээр үнийн бууралттай гарсан хөрөнгийн хувьд дахин үнэлгээгээр нэмэгдсэн дүнг өмнөх бууралтын дүнг нөхөх хэмжээгээр тухайн жилийн ашгаар тусгадаг. Дахин үнэлгээгээр хөрөнгийн дансны үнийг бууруулах тохиолдолд эхлээд тухайн хөрөнгийн өмнөх жилийн үнэлгээнээс үүссэн дахин үнэлгээний нөөцийг бууруулах ба илүү гарсан хэсгийг тухайн жилийн алдагдлаар тусгадаг.

Үйлдвэрлэлийн болон бараа үйлчилгээ хүргэх зориулалтаар болон захиргаа аж ахуйн зориулалтаар эзэмшихээр барьж байгуулж буй үндсэн хөрөнгүүдийг тэдгээрийн өртгөөс шаардлагатай бол хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тайланд тусгадаг. Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу өртөгт мэргэжлийн үйлчилгээний хөлс болон шалгуурт нийцсэн хөрөнгийн хувьд зээлийн хүүгийн өртгийг оруулдаг. Барилгын ажил дуусч зориулалтаар нь ашиглахад бэлэн болсон үед эдгээр хөрөнгийг зохих төрлийн хөрөнгөөр ангилж бүртгэдэг. Эдгээр хөрөнгийн элэгдлийг хөрөнгийн зориулалтаар нь ашиглахад бэлэн болсон үеэс тооцож эхлэнэ.

Дахин үнэлсэн барилгын элэгдлийг тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг. Дахин үнэлсэн хөрөнгийг худалдах эсвэл ашиглалтаас хасах үед дахин үнэлгээний санд үлдсэн нэмэгдлийг хуримтлагдсан ашиг руу шууд шилжүүлнэ.

Тоног төхөөрөмж, тавилга болон бусад үндсэн хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнэ бууралтыг хассан дүнгээр тусгасан.

Үндсэн хөрөнгө (барьж байгуулж буй хөрөнгөөс бусад)-ийн өртөг эсвэл дахин үнэлгээний дүнгээс ашиглалтын хугацааны эцэст үлдэх өртгийг хассан дүнг шулуун шугамын аргаар дараах тооцоолсон ашиглах жилд хувааж зардалд бичиж элэгдлийг бүртгэдэг. Үүнд:

Барилга байгууламж	40
Тоног төхөөрөмж	10
Бусад хөрөнгө	10
Компьютер	3

Тооцоолсон ашиглалтын жил, үлдэх өртөг болон элэгдлийг бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг. Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн

“АДУУН ЧУЛУУН” ХК

2023 он 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл үндсэн хөрөнгийн зүйлийг бүртгэлээс хасдаг. Үндсэн хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг алдагдалд тусгана

2.8 Орлого хүлээн зөвшөөрөлт

Орлогыг харилцагчаас хүлээн авсан болон хүлээн авах зүйлийн бодит үнэ цэнээр хэмждэг. Орлогыг тооцоолж буй борлуулалтын буцаалт, худалдааны хөнгөлөлт, эдгээртэй ижил төстэй хөнгөлөлтүүдийг хассан цэвэр дүнгээр бүртгэдэг.

2.8.1 Борлуулсан бараа бүтээгдэхүүн

Дараах бүх нөхцөл бүрдсэн тохиолдолд орлогыг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Барааг эзэмших өмчлөхтэй холбоотой эрсдэл ба өгөөж нь худалдан авагчид шилжсэн,
- Барааг өмчлөгчийн хувьд брааг удирдах, зохицуулах үүргээс чөлөөлөгдсөн ба борлуулсан барааг захиран зарцуулах эрхээ алдсан
- Орлогыг найдвартайгаар тооцоолох боломжтой
- Ажил гүйлгээтэй холбоотой эдийн засгийн өгөөж нь Группэд ирэх нь өндөр магадлалтай
- Ажил гүйлгээтэй холбоотой гарсан болон гарахаар хүлээгдэж буй зардлуудыг найдвартайгаар тооцоолох боломжтой

Борлуулсан барааны орлогыг тодорхойлохдоо барааг худалдан авагчид хүргэсэн ба өмчлөгчийн эрх шилжсэн байх ёстой

2.8.2 Хүүгийн орлого

Эдийн засгийн өгөөж нь Компанид ирэх өндөр магадлалтай ба орлогын дүнг найдвартайгаар тооцоолох боломжтой тохиолдолд хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрнө. Хүүг хугацаанаас хамааралтайгаар үндсэн өрийг бодит хүүгийн хувиар үржүүлж хуримтлуулан бүртгэдэг. Бодит хүүгийн хувь гэдэг нь санхүүгийн өрийн хорогдуулсан өртгийг бодох ба хүү тооцох хугацааны турш бүртгэх хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Бодит хүүгийн хувь нь ирээдүйд хүлээн авахаар тооцоолсон бүх мөнгөн төлбөрийг тухайн санхүүгийн хэрэгслийн гэрээний хугацааны туршид хуваарилахад хугацааны эцэс гэхэд анх бүртгэсэн цэвэр дансны үнэтэй яг тэнцүү дүн үлдсэн байхаар дискаунталдаг хүүгийн хувь юм.

2.9 Гадаад валютын ажил гүйлгээ

Төгрөгөөс бусад мөнгөн тэмдэгт нь гадаад валют гэж тооцогддог ба гадаад валютаар хийгдсэн гүйлгээнүүд нь тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэгддэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөр нь тухайн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлэгддэг. Энэхүү гадаад валютын хөрвүүлгийн гүйлгээнээс үүссэн ханшийн зөрүүг тухайн тайлант хугацаанд иж бүрэн орлогын тайлангийн эздийн өмчийн хэсэгт тусгадаг.

Иж бүрэн орлогын тайлангийн өдрөөрх гол нөлөө үзүүлхүйц гадаадын мөнгөн тэмдэгтийн валютын ханш нь дараах байдлаар илэрхийлэгдэж байна:

2022-12-31 2023-12-31

United States Dollar
European Euro

2.10 Зээлийн зардал

Шалгуурт нийцсэн хөрөнгийн олж бэлтгэх, барьж байгуулах ба үйлдвэрлэхэд шууд холбоотой хүүгийн зардлыг тэдгээр хөрөнгийн өртөгт оруулж бүртгэдэг. Шалгуурт нийцсэн хөрөнгө гэдэг нь түүнийг зориулалтаар нь ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход их хэмжээний хугацаа зарцуулдаг хөрөнгийг хэлэх ба уг хөрөнгийг ашиглах ба борлуулахад бэлэн болгох хүртэлх хугацаанд хүүгийн зардлыг хөрөнгийн өртөгт оруулдаг.

Шалгуурт нийцсэн хөрөнгийг санхүүжүүлэхээр хүлээж буй зээлийг сул чөлөөтэй үед нь богино хугацаагаар хүү олох хөрөнгө оруулалтанд ашигласан бол олсон хүүг капиталжуулах хүүгийн зардлыг бууруулж бүртгэнэ.

Бусад бүх зээлийн хүүг тэдгээрийг гарсан жилийн ашиг алдагдлын тайланд тусгана.

2.11 Тэтгэвэр болон бусад тэтгэмжийн өртөг

Компани нь улсын нийгмийн даатгалын системийн хүрээнд ажилчдын цалин болон тэтгэмжийн нийт дүнгээс тодорхой хувиар тооцон ногдуулдаг тухайн жилийн нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрөөс өөр тэтгэвэр тэтгэмжийн хөтөлбөр байхгүй болно. Энэхүү шимтгэл нь тодорхой тэтгэвэр, тэтгэмжийн даатгалд төлсөн шимтгэлийн төлбөрийг ажилчид ажил үүргээ гүйцэтгэж энэхүү шимтгэлийг олох эрх авсан хугацааны зардлаар бүртгэдэг.

2.12 Татвар

Орлогын татварын зардал нь тухайн жилд төлөхөөр тооцсон татвар ба хойшлогдсон татварын нийлбэрээс бүрдэнэ.

2.12.1 Тухайн жилийн орлогын албан татвар

Тухайн жилийн татварын өглөг нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод суурилсан байна. Татвар ногдуулах орлого нь Компанийн санхүүгийн тайлангаар тодорхойлсон ашгаас зөрүүтэй байдаг нь санхүүгийн тайланд тусгагдсан орлого, зарлагын зүйлсийн татвар ногдох, татвар ногдох орлогоос хасагдах хугацаа нь татварын тайлангийн зорилгоор өөр тайлант хугацаанд үүсдэг эсвэл эдгээр нь огт татвар ногдохгүй эсвэл татвар ногдох орлогоос хасагдахгүй байдагтай холбоотой. Компанийн тухайн жилийн татварын өрийг тайлант өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно.

2.12.2 Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлан дахь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татвар ногдуулах орлогыг тооцоход хэрэглэсэн тэдгээрийн татварын суурь хоёрын хоорондын түр зөрүүнд тооцдог. Ерөнхийдөө бүх татвар ногдох түр зөрүүгээр хойшлогдсон татварын өрийг бүртгэдэг. Хойшлогдсон татварын хөрөнгийг бараг бүх хасагдах түр зөрүүнд тооцдог боловч ирээдүйд тэдгээр хасагдах түр зөрүүг шингээхэд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх өндөр магадлалтай эсэхийг харгалздаг. Эдгээр хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг гүүдвил болон татварын ногдуулах орлого ба санхүүгийн ашгийн аль алинд нь нөлөөлдөггүй ажил гүйлгээ (бизнесийн нэгдлээс бусад)-ний үед бусад хөрөнгө бө өр төлбөрийг анх бүртгэхэд үүссэн түр зөрүүгээр бүртгэдэггүй.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэст хянаж үздэг ба уг хөрөнгийг болон хөрөнгийн зарим хэсгийг нөхөхөд хүрэлцэхүйц татвар ногдуулах ашигтай байх магадлал бага болсон бол дансны үнийг бууруулдаг.

Тайлант жилийн татварын зардал нь тухайн жилийн татвар ногдуулах орлогод санхүүгийн байдлын тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын

“АДУУН ЧУЛУУН” ХК

*2023 он 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА*

хувь хэмжээг ашиглан ногдуулсан татварын өр болон өмнөх жилүүдийн татварын өртэй холбоотой залруулгаас бүрдэнэ.

Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг борлуулах, барагдуулах үеийн татварын хувийг ашиглан хэмжих ба тайлант өдрөөр хүчин

төгөлдөр эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой татварын хувь хэмжээгээр тооцож, тодорхойлно. Хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийг хэмжихдээ уг татварыг үүсгэж байгаа хөрөнгө, өр төлбөрийг тайлант өдрийн байдлаар Компани хэрхэн борлуулах, барагдуулахаар төлөвлөж байгаа ба түүнээс хамаарсан татварын нөлөөллийг тусгасан байх ёстой.

2.12.3 Тухайн жилийн болон хойшлогдсон татвар

Тухайн жилийн болон хойшлогдсон татварыг тайлант жилийн ашиг алдагдлаар бүртгэх ба харин тэдгээр нь иж бүрэн орлого эсвэл өмчийн хэсэгт шууд бүртгэгдсэн зүйлстэй холбоотой бол харгалзан иж бүрэн орлого эсвэл өмчин хэсэгт бүртгэдэг. Тухайн жилийн болон хойшлогдсон татвар нь бизнесийн нэгдлийг анх бүртгэхтэй холбоотой бол татварын нөлөөллийг бизнесийн нэгдлийн бүртгэлд оруулж тусгана.

“АДУУН ЧУЛУУН” ХК
2023 он 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3. Мөнгөн хөрөнгө

	2022.12.31 (төгрөг)	2023.12.31 (төгрөг)
3.1 Касс		
Касс дахь мөнгө	500,157.01	1,545,189.41
Дүн	500,157.01	1,545,189.41
3.2 Харилцах		
Банкны харилцах данс /төгрөг/	779,072,385.26	2,487,956.95
Банкны харилцах данс /гадаад валют/		
Дүн	779,072,385.26	2,487,956.95
Мөнгөн хөрөнгийн дүн	779,572,542.27	4,033,146.36

Мөнгөтэй адилтгах хөрөнгө нь мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөдөг, үнэ цэнийн өөрчлөлтөд өртөх эрсдэл багатай богино хугацааны өндөр хөрвөх чадвартай хөрөнгө оруулалтаас бүрддэг.

4. Дансны ба бусад авлага

	2022.12.31	2023.12.31
Дансны авлага	954,388,257.57	1,022,125,266.11
Холбоотой талуудаас авах авлага		
ААНОАТ-ын авлага	13,866.55	13,866.55
ХХОАТ-ын авлага		
НӨАТ-аас авах авлага		6,517,263.69
Бусад авлага	2,960,666.34	
Дүн	957,362,790.46	1,028,656,396.35

5. Бараа материал

Түүхий эд материал	1,375,300,968.36	1,288,206,045.56
Бэлэн бүтээгдэхүүн	86,804,529.40	71,952,492.36
Хангамжийн материал	27,380,139.85	35,160,753.37
Барилгын материал		
Тэсрэх дэлбэрэх материал		
Дүн	1,489,485,637.61	1,395,139,291.29

6. Мал амьтад

Мал амьтад		
Дүн		

“АДУУН ЧУЛУУН” ХК
2023 он 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

	(мян.төг)						
	Барилга	Машин т/төх	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Нийт
2022.12.31	3,824,445.2	3,740,437.4	3,015,958.6	150,159.5	117,228.7	25,491.1	10,873,720.5
Нэмэгдсэн		22,832.7	21,000.0	1,810.5	10,826.2	6,090.9	62,560.2
Хасагдсан							
Шилжүүлсэн							
2023.12.31	3,824,445.2	3,763,270.199	3,036,958.6	151,969.9	128,054.9	31,582.0	10,936,280.7
Эхний үлдэгдэл	1,679,891.6	2,973,139.7	2,239,738.8	140,345	86,915.5	25,491.1	7,145,522.0
Элэгдлийн зардал	235,959.4	179,957.4	162,147.5	3,345.1	12,425.7	40808	594,244.1
Хасагдсан							
Эцсийн үлдэгдэл	1,915,851.0	3,153,097.1	2,401,886.4	143,690	99,341	25,899.6	7,739,766.1
Цэвэр дүн:							
2022.12.31	2,144,553.6	767,297.7	776,219.8	9,814.2	30,313.2		3,728,198.5
2023.12.31	1,908,594.2	610,172.9	635,072.3	8,279.0	28,713.7	5,682.4	3,196,514.6

8. Дансны ба бусад өглөг

	2022.12.31 (төгрөг)	2023.12.31 (төгрөг)
Дансны өглөг	120,494,124.27	190,561,474.09
Цалингийн өглөг	89,657,541.11	63,835,013.75
АМНАТ -ийн өглөг		41,470,513.88
ХХОАТ-ын өглөг	47,289,285.06	41,175,484.93
Бусад татвар өглөг	1,274,578.66	105,672,874.52
НӨАТ-ын өглөг	57,439,944.83	199,859,702.87
Ногдол ашгийн өглөг	21,771,537.00	70,653,387.00
Богино хугацаат зээл	426,533,500.05	310,000,000.00
Бусад өглөг	3,950,972.20	13,772,920.67
Дүн	768,411,483.18	1,037,001,371.71

9. Эзний өмч

	2022.12.31 (төгрөг)	2023.12.31 (төгрөг)
Хувийн өмч	970,613,140.82	970,613,140.82
Халаасны хувьцаа	-174,466,292.0	-174,466,292.0
Нэмж төлөгдсөн капитал	-425,199,852.0	-425,199,852.0
Дахин үнэлгээний нөөц	4,883,798,132.47	4,883,798,132.47
Хуримтлагдсан ашиг/алдагдал	1,068,017,224.85	-342,743,972.52
Дүн	6,322,762,354.14	4,912,001,156.77

“АДУУН ЧУЛУУН” ХК
2023 он 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

10. Бусад олз ба гарз

	(төгрөг) 2022.12.31	(төгрөг) 2023.12.31
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, (гарз)	-310,933.66	-1,659,263.08
Хүүгийн орлого, (зардал)	23,009,949.0	328,488.39
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
Бусад олз (гарз)		
Дүн	22,699,015.3	-1,330,774.69

11. Борлуулалт, маркетингийн зардал ба Ерөнхий ба удирдлагын зардал

Зардал	Борлуулалт маркетингийн зардал		Ерөнхий ба удирдлагын зардал	
	2022.12.31 (төгрөг)	2023.12.31 (төгрөг)	2022.12.31 (төгрөг)	2023.12.31 (төгрөг)
Ажилчдын цалингийн зардал		468,622,270		
Нийгмийн даатгалын шимтгэл		66,615,976		
Ашиглалтын зардал төлсөн	3,525,190	6,915,841	4,730,920	
Албан томилолтын зардал	3,241,000		3,494,382	
Бичиг хэргийн зардал	300,282	67,518	99,636	
Шуудан холбооны зардал	3,691,424	1,280,779	540,192	
Засварын зардал	40,551,391	1,613,872	14,214,177	
Мэргэжлийн үйлчилгээний зардал	1,280,000	572,727	1,319,000	
Элэгдлийн зардал	2,560,616	125,931,664	39,554,505	
Даатгалын зардал				
Зээлийн хүүгийн зардал				
Цэвэрлэгээ үйлчилгээний зардал				
Хулээн авалтын зардал				
Тээврийн зардал	1,260,000		8,700,000	
Шатахууны зардал	73,025,258	12,257,519	56,802,942	
Бусад зардал	8,754,725	2,176,164	12,085,000	
Дүн	138,189,886	686,054,130	141,540,755	

12. Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу 3 тэрбум төгрөг хүртэлх албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 10 хувиар, 3 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 3 тэрбум төгрөгөөс дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж албан татвар ногдуулдаг.

13. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ ба үлдэгдэл

16.1 Холбоотой талуудын үлдэгдэл

Тайлант хугацааны эцэст холбоотой талуудын авлага өглөгийн үлдэгдэлгүй байна.

14. Гадаад валютын эрсдлийн удирдлага

Компанид төгрөгөөс өөр валютаар үүссэн худалдан авалт болон төлбөртэй холбоотойгоор гадаад валютын ханшийн эрсдэл үүсдэг.

15. Гэрээний үүрэг

Компанид 2023 оны 12 сарын 31-ний байдлаар томоохон капитал худалдан авалтын үүрэг байхгүй.

16. Болзошгүй өр төлбөр бө болзошгүй хөрөнгө

16.1 Болзошгүй өр төлбөр

Хэвийн бизнесийн үйл ажиллагааны явцад Компани нь хууль, эрх зүйн асуудлууд, гомдол нэхэмжлэлд өртөж болно. Ийм хууль, эрх зүйн асуудал, гомдол нэхэмжлэл байгаа бол түүнээс гарах үүрэг хариуцлага нь Компанийн ирээдүйн үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн байдалд их хэмжээний сөрөг үр дагаврыг бий болгохгүй гэж Компанийн удирдлага итгэж байна

16.2 Татварын систем

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монголын Засгийн Газар бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт шинэчлэлтийг хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.

Эдгээр хууль журмуудын өөрчлөлтүүд нь боловсруулалт муутай, тогтсон нэг ойлголтгүй мөн эрх бүхий байгууллагууд өөр өөрсдийнхөөрөө тайлбарладаг зэрэг нийтлэг шинжтэй байдаг. Өөр өөр эрх бүхий байгууллагууд татварын хуулийн хэрэгжүүлэлтэнд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Компани татварын хууль тогтоомжийн ойлголт дээрээ үндэслэн бүх татваруудыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн Компанид татварын эрсдэл байсаар байна.

16.3 Болзошгүй хөрөнгө

2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр Компани бэлтгэн нийлүүлэгч болон харилцагчдийн эсрэг мэдүүлсэн ямар нэгэн зарга нэхэмжлэл байхгүй.

17. Тайлагналын дараах үйл явдлууд

Санхүүгийн тайлангуудад нөлөөлөхүйц, тодруулахыг шаарддаг үйл явдал гараагүй.

Бэлтгэсэн: Аудитор

Хянасан: Захирал



/ Д.Дамдимаа /

/ Ц.Баярболд /